



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/49

Баян-Адарга сум

Нийтийн хог цэвэрлэгээний ажлыг
зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1, 9.4.4, 9.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Нийтийн хог цэвэрлэгээг сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд 2026 оны 04 дүгээр сарын 24, 25-ны өдөр зохион байгуулсугай.

2.Нийтийн эдэлбэрийн хуваарилсан газар, өөрийн өмчлөл, эзэмшлийн газраа бүрэн цэвэрлэж, хогийн нэгдсэн цэгт хүргэж, зохион байгуулж байгаа талд хүлээлгэн өгөхийг иргэн, аж ахуй нэгж, албан байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг тээвэрлэж, зөөвөрлөх шатахууны зардлыг байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг Төсвийн Нягтлан бодогч (Б.Агиймаад)-д зөвшөөрсүгэй.

4.Хог цэвэрлэгээний ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Дуурлиг багийн Засаг дарга (М.Нямдорж)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Орлогч (Н.Ганбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  О.ЦХАГВАДОРЖ



2026 оны 04 дүгээр сарын 24 ний өдрийн
1111 дугаар Захирамжийн / дүгээр хавсралт



НИЙТИЙН ХОГ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

2026.04.20

Дуурлиг

Нэг: Зорилго

Нийтийн эзэмшлийн талбай, зам гуу жалга, хөдөөний өрхийн хаваржаа өвөлжөө, төвийн айл өрх, аж ахуй нэгж, байгууллагуудын эзэмшил хашаа, гудамж талбайд хуримтлагдсан хог хаягдлыг цэвэрлэх, ачиж тээвэрлэх, хог хаягдал тээвэрлэлтийг эрчимжүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

Хоёр: Хугацаа, чиглэл

- 1.Нийтийн хог цэвэрлэгээг 2026 оны 04 сарын 24, 25-ны өдөр нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулна
- 2.Ногоон байгууламж, үерийн хамгаалалтын далан сувгийн хог хаягдлыг цэвэрлэх, айл өрх, аж ахуй нэгж байгууллагуудын хог хаягдлын ачилт, тээвэрлэлтийг хийх.
- 3.Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайг хуваарилан цэвэрлэх
- 4.Хур болон үүсмэл хогийг төвлөрсөн хогийн цэгт хүргэх
- 5.Төрийн алба хаагчдыг нийтийн их цэвэрлэгээнд оролцуулах
- 6.Хог хаягдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох хууль
- 7.тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах
- 8.Иргэд, олон нийтэд хог хаягдлын тухай, байгаль орныг хамгаалах тухай хууль, тогтоомжийг сурталчлах

Гурав: Хамрах хүрээ, хариуцан ажиллах албан тушаалтан

Сумын нийт иргэд, өрх, байгууллага оролцоно. Нэгдсэн удирдлагаар Дуурлиг багийн засаг дарга М.Нямдорж хангаж, Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Гүрсүрэн, Байгаль хамгаалагч О.Батсуурь, "Адарга тохижилт" ОНӨААТҮГ-ын дарга Л.Баярхүү, Багийн Засаг дарга нар, төрийн албан хаагчид өөрсдийн хуваарьт газарт хяналт тавьж ажиллана.

Дөрөв: Иргэн, өрх, байгууллагын хүлээх үүрэг

№	Байгууллага	Хариуцах ажил
1	Засаг даргын Тамгын газар	<ul style="list-style-type: none"> • Иргэн, айл өрх, аж ахуй нэгж байгууллагуудыг цэвэрлэгээнд өргөнөөр хамруулах, гудамж, зам талбай, хур хог хаягдал цэвэрлэх, орчны аюулгүй байдлыг хангах • Багийн засаг дарга, БОХУБ, байгаль хамгаалагч нар хэсгийг ахлан оролцоно. • Цэвэрлэгээ зохион байгуулах талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээллэх, цэвэрлэгээний ажлын үр дүнгийн талаар олон нийтэд хүргэх, аж ахуй нэгж байгууллага иргэдийг цэвэрлэгээнд нэгдэхийг уриалах, сурталчлах
2	ИТХ, ЗДТГ, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Цагдаа, ЭМТ, Соёлын төв, ЭХАС, Монгол хатдын өргөө	<p>Өөрийн байгууллагын орчны 100метр болон хуваарийн дагуу нийтийн эзэмшлийн зам, гудамж талбайг цэвэрлэх, цэвэрлэгээнд шаардлагатай эд зүйлс /багаж, шуудай, бээлий/-ийг хариуцсан байгууллага бүр өөрсдөө гаргана. Мөн</p> <ul style="list-style-type: none"> • Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Цагдаа 1 ш хог тээвэрлэх ачааны автомашиныг түлш шатахуунтай нь гаргах • Эрэн хайх аврах салбар 1ш хог тээвэрлэх ачааны автомашиныг түлш шатахуунтай нь гаргах • Ерөнхий Боловсролын сургууль 1ш хог тээвэрлэх ачааны автомашиныг түлш шатахуунтай нь гаргах • Цэцэрлэг 1ш хог тээвэрлэх ачааны автомашиныг түлш шатахуунтай нь гаргах • Соёлын төв 1ш хог тээвэрлэх ачааны автомашиныг түлш шатахуунтай нь гаргах • Эрүүл мэндийн төв 1ш хог тээвэрлэх ачааны автомашиныг түлш шатахуунтай нь гаргах • “Адарга тохижилт” ОНӨААТҮГ, “Монгол хатдын өргөө цогцолбор” ОНӨААТҮГ нийлж 1 ш хог тээвэрлэх ачааны автомашиныг түлш шатахуунтай нь гаргах


3	Сумын нийт аж ахуй нэгж байгууллагууд	<ul style="list-style-type: none"> • Өөрийн байгууллагын орчны 50метр хүртэлх хуваарьт газрын цэвэрлэгээг зоион байгуулах • Нийтийн эзэмшлийн талбайн өөрт оногдсон хэсэгт 2-оос доошгүй хүн гаргах, багаж хэрэгсэлийг өөрсдөө гаргах, мөн байгууллага бүр 5литр дизель түлш гаргах • Хогийн савны өнгө үзэмжийг сэргээх, угааж ариутгах • Ангилан ялгах зориулалттай хогийн савтай болох
4	Айл өрх, иргэд	<ul style="list-style-type: none"> • Хашааны урд, хойд 50метр газрыг цэвэрлэгээг хийх • Нийтийн эзэмшлийн газарт малын өтөг бууц асгасан айл өрхүүд цэвэрлэх • Ангилан ялгах хогийн савыг иргэн бүр хэвшүүлэх, хогоо ангилан ялгаж асгах
5	“Дуурлигийн-Овоо” ХХК, “Хөтөлж Баян Дуурлиг” ХХК	<ul style="list-style-type: none"> • Нийтийн эзэмшлийн талбайн өөрт оногдсон хэсэгт 3-аас доошгүй хүн гаргах, багаж хэрэгсэлийг өөрсдөө гаргах • Мөн 2 ковш гаргаж хогийн цэгийн зүүн болон урд талын хогийг төвлөрсөн цэг рүү түрж оруулах

Тав: Тайлагнах

Бүх нийтийн их цэвэрлэгээ, орчны аюулгүй байдлыг хангах ажил зохион байгуулсан аж ахуй нэгж, байгууллага (харьцуулсан фото зураг) 2026 оны 04 дугаар сарын 30-ны дотор илтгэх хуудсаар сумын Засаг даргын Тамгын газарт ирүүлэх Үр дүнг сум, багийн албан ёсны сошиал хуудас, сайтаар сурталчлах

Боловсруулсан: Дуурлиг багийн Засаг дарга М.Нямдорж

2026 оны 04 дүгээр сарын 11 ний өдрийн
 111 дугаар Захирамжийн 2 дугаар хавсралт



НИЙТИЙН ЭДЭЛБЭР ГАЗРЫН ХОГ ЦЭВЭРЛЭХ ХУВААРЬ

2026.04.20.

Дуурлиг

№	Хариуцах байгууллага	Хог цэвэрлэгээ хийх газрын байршил	Удирдан зохион байгуулж цэвэрлэгээ хийлгэх албан тушаалтан	техник
1	Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Хавсралтаар орсон талбайг цэвэрлэх	ЗДТГазрын дарга С.Бат-Эрдэнэ ИТХ-ын дарга Г.Жамцанги	ИТХ, ЗДТГ
2	Засаг даргын Тамгын газар			
3	Цагдаа			
4	Эрүүл мэндийн төв	Хавсралтаар орсон талбайг цэвэрлэх		ЭМТ
5	Цэцэрлэг	Хавсралтаар орсон талбайг цэвэрлэх		Цэцэрлэг
6	Онцгой байдлын газрын Эрэн хайх аврах салбар	Хавсралтаар орсон талбайг цэвэрлэх	Хууль эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, ЭХАС, Татварын байцаагч	ЭХАСалбар
7	Ерөнхий боловсролын сургууль	Хавсралтаар орсон талбайг цэвэрлэх	Сайхан багийн засаг дарга, Адарга багийн засаг дарга, ХХҮйлчилгээний мэргэжилтэн, Цагдаа	СӨБ
8	Соёлын төв, Цаг уурын харуул	Хавсралтаар орсон талбайг цэвэрлэх	Төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн, Соёлын төв	Соёлын төв
9	Адарга тохижилт ОНӨААТҮГ	Хавсралтаар орсон талбайг цэвэрлэх	МЭТ-ийн дарга, Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо хариуцсан мэргэжилтэн	Хадгаламж хоршоо
10	Монгол хатдын өргөө цогцолбор ОНӨААТҮГ			
11	ААН байгууллагууд			
12	Хаан банк			
13	Төрийн банк			
14	Хадгаламж зээлийн хоршоо			
15	Ахуй үйлчилгээ			

16	Эрчим, ШТС	Хавсралтаар орсон талбайг цэвэрлэх	Мал эмнэлэгийн тасгийн Тархвар зүйч, Хүүхэд, гэр бүл хариуцсан нийгмийн ажилтан	Эрчим, ШТС
17	ЕБС-ийн ахлах ангийн сурагчид	Нийтийн эзэмшлийн тоглоомын талбай,	Нийгмийн бодлогын мэргэжилтэн, Улсын бүртгэгч,	ЕБС
18	Аж ахуй нэгж	Хашааны урд, хойд 100 метр газрыг цэвэрлэх Нийтийн эзэмшлийн газарт малын өтөг бууц асгасан айл өрхүүд цэвэрлэх	БОАХМ, Байгаль хамгаалагч, Багийн Засаг дарга нар	Өөрсдийн техник

Айл өрхийн цэвэрлэгээг хариуцаж зохион байгуулах ажлыг хариуцах албан байгууллага

1	Өрөлт хороо	Айл өрх	ИТХ-ын ажлын албаны ажилтан, нийгмийн даатгалын байцаагч, Жаргалант багийн Засаг дарга, Архив бичиг хэргийн эрхлэгч	Адарга тохижилт
2	Эрчим хороо	Айл өрх	Татварын байцаагч, ЕБС, Төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн	Адарга тохижилт
3	Онон хороо	Айл өрх	Эрэн хайх аврах салбар	Адарга тохижилт
4	Хийдээс хойш айл өрх	Айл өрх	Хууль эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо хариуцсан мэргэжилтэн	Адарга тохижилт
5	Булаг	Айл өрх	Мал эмнэлэгийн тасгийн Тархвар зүйч, Хүүхэд гэр бүл хариуцсан нийгмийн ажилтан, БОАХМ, Дуурлиг багийн Засаг дарга, Улсын бүртгэгч	Адарга тохижилт
6	Төв хэсэг	Айл өрх	Сайхан, Адарга багийн Засаг дарга, Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Цагдаа Нийгмийн бодлогын мэргэжилтэн	Адарга тохижилт

Боловсруулсан: Дуурлиг багийн Засаг дарга М.Нямдорж